

**118. СУРГАЛТЫН БОДЛОГО  
БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Батлагдсан: 2015-01-29

Дугаар:57

Хавсралт:	Нэмэлт тайлбар:	
Тараасан: 2015-01-30, 2015-05-28	Шинэчилсэн:2015.05.26 №А/39	Хуудас: 7

**118.1.ЗОРИЛГО**

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, давтан, мэргэшүүлж сургах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**118.2.ХАМРАХ ХҮРЭЭ, ЗАРЧИМ**

118.2.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

118.2.2.Сургалтын төлөвлөлтөд байгууллага, алба хаагчийн эрэлт хэрэгцээг зохистой хослуулах, алба хаагчид сонголт хийх боломж, нөхцлийг бүрдүүлэх, мэргэжлийн сургалтын чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулах, ил тод, тэгш, шударга, сургалт үр дүнтэй байх зарчмыг удирдлага болгоно.

**118.3.ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

118.3.1.Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт, хөгжлийн талаар цагдаагийн төв байгууллагаас дараах үндсэн чиглэлийг баримтална:

а/хүний нөөцийн сургалт, хөгжлийн урт, богино хугацааны стратеги, бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;

б/сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу цагдаагийн болон харуул, хамгаалалтын анхан шатны мэргэжлийн болон олон нийт-цагдаагийн ажилтныг бэлтгэх сургалтыг зохион байгуулах;

в/цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн дээд /бакалавр/ боловсролтой, мэдлэг, ур чадвартай алба хаагчийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалтын байгууллагад захиалгаар бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

г/гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, доктор, адъюнктур, удирдах ажилтныг бэлтгэх сургалтад алба хаагчдыг суралцуулж, хөгжүүлэх;

д/гадаад, дотоодын тэтгэлэгт болон мэргэшүүлэх сургалтад алба хаагчийг суралцуулж, боловсролын зэргийг нь дээшлүүлж, хөгжүүлэх;

е/байгууллагын болон алба хаагчийн сургалтын хэрэгцээг харгалзан алба хаагчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх давтан болон мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах;

ж/алба хаагчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх бүтээлч санаачлагыг дэмжиж, тэдний өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлэх;

з/алба хаагчийн сургалт, хөгжлийн тогтолцоо, агуулга, арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга шинэчилж, боловсронгуй болгох.

**118.4. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО**

118.4.1.Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоо нь дараах сургалтын төрлүүдээс бүрдэнэ:

а/цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт;

б/цагдаа - мэргэжлийн дээд боловсролын сургалт/ бакалавр, магистр, доктор, адъюнктур/;

в/давтан, мэргэшүүлэх, ур чадварын болон ажлын байран дахь үргэлжилсэн сургалт;

г/иргэд, олон нийтэд чиглэгдсэн бусад сургалт.

## **118.5.ЦАГДААГИЙН АНХАН ШАТНЫ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ**

118.5.1.Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтыг цагдаагийн төв байгууллагын захиалгаар хууль сахиулагч бэлтгэх сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл бүхий сургалтын нэгжид Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу өдрийн хэлбэрээр, 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар зохион байгуулна.

118.5.2.Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтад цагдаагийн албан тушаалд шинээр томилогдох иргэнийг сонгон шалгаруулах шалгалтад тэнцсэн, бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй иргэнийг элсүүлэн суралцуулж төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх олгоно.

118.5.3.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс нь цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хариуцна.

## **118.6.ЦАГДАА-МЭРГЭЖЛИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ**

118.6.1.Цагдаагийн мэргэжлийн бакалаврын зэргийн боловсролтой алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн ажилтан, хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, академид бэлтгэнэ.

118.6.2.Бакалаврын зэрэглэлийн өдрийн хэлбэрийн сургалтад цагдаагийн байгууллагад 1-ээс доошгүй жил ажилласан, эчнээ хэлбэрийн сургалтад цагдаагийн байгууллагад 3 ба түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг харьяа байгууллагын саналыг харгалзан тус тус элсүүлэн суралцуулна. Энэ тохиолдолд Хүний нөөц, сургалтын хэлтсээс сургалтын гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд дүгнэнэ.

118.6.3.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төв хамтран цагдаагийн мэргэжлийн бакалаврын боловсролтой алба хаагчийн ажиллах ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусгагдсан мэдлэг, ур чадвар, хандлагад тавигдах шаардлагыг харгалзан захиалгаар бэлтгүүлэх мэргэжлийн чиглэл, индексийн талаар холбогдох байгууллагад санал өгөх, мэргэжлийн тодорхойлолтыг сургалтын байгууллагатай хамтран боловсруулах, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох саналаа холбогдох сургалтын байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.6.4.Гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн цагдаагийн удирдах ажилтан бэлтгэх бакалавр, магистрын сургалтад цагдаагийн байгууллагад 6, түүнээс дээш жил ажилласан, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн болон цагдаагийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчийг ажлын үр дүн, харьяа байгууллагын саналыг харгалзан элсүүлэн суралцуулна.

118.6.5.Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургууль, академид суралцаж байгаа сонсогч, алба хаагч, бусад энгийн их, дээд сургуулийн оюутныг цагдаагийн байгууллагад хийх танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг Цагдаагийн төв байгууллагын дангаар болон хамтран баталсан эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, удирдамж зэргийн дагуу зохицуулна.

118.6.6.Өмнөх боловсролын зэргийн сургалт төгссөнөөс хойш 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан цагдаагийн алба хаагчийг гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн магистр, докторантур, адъюнктурт элсүүлэн суралцуулна.

118.6.7.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс холбогдох сургалтын байгууллагуудтай хамтран цагдаагийн байгууллагын тогтолцоо, бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлын чиглэлээр хийх шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, чиглэлийг боловсруулан судалгааны ажлыг захиалгаар гүйцэтгүүлэх гэрээг магистр, доктор, адъюнктурт элссэн алба хаагчтай байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэнэ.

118.6.8.Цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нь алба хаагчийн магистр, доктор, адъюнктын судалгааны ажлын хувийг цагдаагийн төв байгууллагын номын санд авч албаны хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх, бүтээлийг алба хаагчдад сурталчлах, шаардлагатай бол гарын авлага, зөвлөмж хэлбэрээр хэвлүүлж нийтийн хүртээл болгох, судалгааны ажлын дүгнэлт, дэвшүүлсэн саналыг судалж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, танилцуулж, шийдвэрлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.6.9.Гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн дээд боловсролын зэргийн /бакалавр, магистр, доктор/ сургалт нь тухайн сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдана.

## **118.7.ДАВТАН, МЭРГЭШҮҮЛЭХ, УР ЧАДВАРЫН БОЛОН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ**

118.7.1.Цагдаагийн алба хаагчийг гадаад, дотоодод давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтад хамруулах болон төрийн ба төрийн бус байгууллага, их, дээд сургууль, академитай хамтарч сургалтыг зохион байгуулах ажлыг цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төв, бүсийн сургалтын төв, нутаг дэвсгэр болон тодорхой нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага тус тус хариуцан танхмийн, дадлагын, зайны сургалтын хэлбэрээр тус тус зохион байгуулна.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.7.2.Давтан сургалт нь цагдаагийн алба хаагчийн нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг дээшлүүлж, дадал, чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэх ба ажлын 5-10 хоногийн хугацаагаар зохион байгуулагдана. Сургалтын агуулгын 60 ба түүнээс дээш хувь нь алба хаагчийг дадлагажуулж, чадваржуулах сургалт байна.

118.7.3.Мэргэшүүлэх сургалт нь алба хаагчдын тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, тактикийн мэдлэг, ур чадварын түвшинг нь дээшлүүлэх, цагдаагийн тодорхой албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшлийн чадамж олгох болон түвшинг нь дээшлүүлэх сургалт бөгөөд ажлын 4 цагаас 1 сар хүртэл хугацаанд зохион байгуулагдана.

118.7.4 Ур чадварын сургалт нь алба хаагчдын ур чадварыг ахиулах, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх чиглэгдэх ба ажлын 3-5 хоногийн хугацаагаар зохион байгуулагдана. Сургалтын агуулга нь дадлагажуулах, чадваржуулах сургалт байна.

118.7.5.Шавь сургалт буюу алба хаагчийг ажлын байр /албан тушаал/-нд дахь үргэлжилсэн сургалт нь шинээр томилогдсон алба хаагчдад ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, түвшинг нь дээшлүүлэх, ажил, албанд хандах хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэх ба энэ сургалтыг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 239-д зааснаар зохицуулна.

118.7.6.Цагдаагийн албанд анх орсон, цагдаагийн ахлах, дунд цолны албан тушаалд дадлагажих ажилтанаар ажиллаж байгаа иргэнийг холбогдох журмын дагуу ажлын үр дүнг харгалзан 1 сараас доошгүй хугацааны чадавхижуулах сургалтад хамруулна.

118.7.7.Алба хаагчийг удирдах албан тушаалд дэвшүүлэн томилох болон өөр ажлын байр /албан тушаал/-нд томилох тохиолдолд тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалтад заавал хамруулна.

118.7.8.Алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, хөгжүүлэх чиглэгдсэн тусгай сургалтад 3 сар хүртэл хамруулж болно.

118.7.9.Цагдаагийн алба хаагчийг 3 жил тутам давтан сургалтад, 1 жил тутам мэргэшүүлэх сургалтад хамруулах бөгөөд мэргэжлийн алдаа, дутагдал, сахилга, ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан алба хаагчийг сургалтын давтамжийн хугацаа харгалзахгүйгээр албадан сургалтад хамруулах ажлыг сургалтын ажил хариуцсан холбогдох нэгжүүд зохион байгуулна.

118.7.10.Алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтыг тодорхой орон зайнаас мэдээлэл, харилцааны хэрэгслүүдээр дамжуулан зайны сургалтын хэлбэрээр /утас, ном, сурах бичиг, гарын авлага, цахим харилцаа, видео г.м/ зохион байгуулж болно.

118.7.11.Нутаг дэвсгэрийн онцлог, ажил, үүргийн чиглэл, нөхцөл байдлаас хамааран бүсчилэн, хээрийн дадлага хосолсон хэлбэрийн сургалтыг зохион байгуулж болно.

## **118.8 ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭГДСЭН БУСАД СУРГАЛТ**

118.8.1.Цагдаагийн төв байгууллага нь холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу харуул, хамгаалалтын болон олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх, иргэний зөвлөл, иргэдэд зориулсан сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулна.

## **118.9.СУРГАЛТЫН АЖЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

118.9.1.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс нь цагдаагийн байгууллагын сургалтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт, хөгжлийн стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, цагдаагийн төв байгууллагын даргаар батлуулан, хэрэгжүүлнэ.

118.9.2.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төв нь цагдаагийн байгууллагын хэмжээний алба хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг, бүсийн сургалтын төв нь цагдаагийн алба хаагчдын бүсчилсэн сургалтыг, нутаг дэвсгэрийн болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага дотооддоо ажлын байранд дадлагажуулах сургалтыг тус тус хариуцан зохион байгуулна.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.9.3.Цагдаагийн төв байгууллагын Тэргүүн дэд дарга цагдаагийн байгууллагын сургалтын ажлыг арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй сургалт арга зүйн зөвлөлийг удирдана.

Зөвлөлийг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар Иргэний зөвлөлийн гишүүн, Хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн бүрэлдэхүүн дэх цагдаагийн мэргэжлийн

алба хаагчийг бэлтгэх сургуулийн захирал, Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төвийн удирдах албан тушаалтнууд, сургалтын ахлах мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.9.4.Сургалт арга зүйн зөвлөл нь ажлаа жил, улирлаар төлөвлөн төлөвлөгөөт болон цаг үеийн ажил, арга хэмжээг зохион байгуулах бөгөөд тус зөвлөлийн боловсруулсан зөвлөмж, чиглэл нь цагдаагийн төв байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэр, тушаалаар баталгаажсаны дараа хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

118.9.5.Зөвлөл доорх үйл ажиллагааг явуулна:

а/цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартуудтай танилцаж, зөвлөх;

б/алба хаагчийн давтан сургалт, мэргэшүүлэх болон бусад богино хугацааны сургалтын явц, үр дүнд дүн шинжилгээ хийж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

в/албаны болон мэргэжлийн сургалтын талаар дүрэм, журам, заавар, зөвлөмжийн төсөл боловсруулах, санал өгөх, сургалттай холбогдох хууль, эрхийн актуудыг хэрэгжүүлэх талаар цагдаагийн байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр хангах;

г/гадаад, дотоодын сургууль, байгууллагын дэвшилтэт арга, технологийг судлах, дэмжин дэлгэрүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

д/цагдаагийн байгууллагын сургалтын ажил хариуцсан алба хаагчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тэдэнд зориулсан сургалт, семинар зохион байгуулах;

ж/алба хаагчдын сургалтад ашиглах ном, гарын авлага, сургалтын киног танилцан зөвлөх, дэмжлэг үзүүлэх;

з/цагдаагийн алба хаагчийн сургалт, хөгжлийн жил, улирлын тайланд дүн шинжилгээ хийж зөвлөлийнхөө хуралдаанаар хэлэлцэн аргачлал, зөвлөмж боловсруулж хүргүүлэх;

и/давтан, мэргэшүүлэх сургалтын сургагч багш нарын мэдлэг, ур чадварын түвшинг үнэлэх, аргачилсан зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

118.9.6.Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага нь алба хаагчдын давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгааг хийж жил бүрийн 10 дугаар сард багтаан Сургалтын төвд ирүүлнэ.

Сургалтын төв нь судалгааг нэгтгэж, дүгнэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт хамтран зохион байгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх, цагдаагийн байгууллагын тухайн жилийн сургалтын нэгдсэн график, төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлнэ.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.9.7.Цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, алба хаагчдынхаа сургалтын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн ажлын байранд зохион байгуулах /албаны/ жилийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж, хэрэгжүүлэх ба сургалтын төлөвлөгөөний хувийг цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлнэ.

Байгууллага дээр явагдах нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа 2 цагаас хэтрэхгүй байна.

118.9.8.Цагдаагийн байгууллагууд байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулахгүй байх шаардлагыг харгалзан дараагийн жилд бүх шатлал, боловсролын зэргийн сургалтад суралцуулах алба хаагчдын тоо, судалгааг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлнэ.

118.9.9.Гадаад дотоодын их, дээд сургууль, академийн мэргэжлийн дээд боловсролын зэргийн сургалт /бакалавр, магистр, доктор/-д суралцах алба хаагчийн асуудлыг алба хаагчийн ажиллаж буй байгууллагын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох материалыг саналын хамт тухайн жилийн элсэлтийн шалгалтын журамд заасан хугацаанд цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлнэ.

118.9.10.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс гадаад, дотоодын их, дээд сургуулийн дээд боловсролын зэргийн сургалтад суралцах алба хаагчдын материалыг хянан шаардлагатай бол холбогдох хууль тогтоомийн дагуу нэмэлт судалгаа хийж, элсүүлэн суралцуулах санал, холбогдох материалыг сургалтын байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

118.9.11.Их, дээд сургуулийн магистр, доктор, адъюнктур, удирдах ажилтан бэлтгэх сургалтад суралцах алба хаагчдын асуудлыг цагдаагийн төв байгууллагын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

118.9.12.Суралцах алба хаагчдын ажлыг зохицуулах, сургалтад хамрагдах боломж нөхцлийг харьяа цагдаагийн байгууллага хангана. Алба хаагчдын сургалтад хамрагдсан бүртгэл, судалгааг байгууллага бүр хөтөлж, мэдээллийг “Ухаалаг систем” сургалтын цахим санд оруулж, тогтмол нэмэлт, тодотгол хийж, жил бүрийн 12 дугаар сард багтаан цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлнэ.

Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс судалгааг нэгтгэх, алба хаагчийн хувийн хэргийн бүртгэлд тэмдэглэх ажлыг хариуцан зохион байгуулна.

118.9.13.Сургалтад хамрагдах алба хаагчдыг ажлаас түр болон албанаас чөлөөлөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ. Алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар ажлаас чөлөөлж суралцуулах тохиолдолд сургалт эхлэхээс 1 сараас доошгүй хугацааны өмнө санал, холбогдох материалыг цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлвэл зохино.

118.9.14.Алба хаагч өөрийн хүсэлтээр 1 сар хүртэл хугацааны сургалтад хамрагдах тохиолдолд асуудлыг байгууллагынхаа даргад, түүнээс дээш хугацааны сургалтад хамрагдахаар бол харьяалах дээд шатны байгууллагаараа уламжлан цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст асуудлыг танилцуулж, зохих зөвшөөрөл авсаны дараа суралцана.

118.9.15.Цагдаагийн алба хаагч байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр хувиараа гэрээ, хэлцэл хийж гадаад дотоодын академи, их, дээд сургууль, коллежид элссэн тохиолдолд сургалтын чөлөө олгохгүй бөгөөд төгсөхөд нь ажлын байраар хангах үүргийг цагдаагийн байгууллага хүлээхгүй.

118.9.16.Алба хаагчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, сургалтын багц цагийг хангахтай холбогдон үүсэх харилцааг журмаар зохицуулна.

118.9.17.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс нь цагдаагийн анхан шатны мэргэжлийн болон гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн дээд мэргэжлийн боловсрол /бакалавр, магистр, доктор, адъюнктур, удирдах ажилтан бэлтгэх/-ын зэргийн сургалтад суралцаж байгаа иргэн, алба хаагчтай сургалтын гэрээ байгуулан, суралцуулж, төгсөгчдийг ажлын байраар хангана.

118.9.18.Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн мэргэжлийн алба хаагчийг захиалгаар бэлтгэж буй сургалтын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.

118.9.19.Цагдаагийн байгууллага тухайн сургалтын жилийн эхний сард багтаан цагдаагийн байгууллагын сургалтын нэгдсэн график, төлөвлөгөө, байгууллага дотооддоо ажлын байранд зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг алба хаагчдад танилцуулж, сурталчлахаас гадна сургалтын жилд алба хаагчийн бие даан уншиж судлах хууль, тогтоомж, эрх зүйн акт, ном гарын авлага, баримт бичгүүдийн жагсаалтыг албан ёсоор гаргаж өгсөн байна.

118.9.20.Цагдаагийн алба хаагчийн сургалтын ажлыг хариуцсан нэгжүүд болон цагдаагийн байгууллага тухайн сургалтын жилд шинээр боловсруулсан лекц, бодлого, дасгал, сургалтын кино, сургалтад ашиглах бусад хэрэглэгдэхүүнийг нэгтгэн сургалтын гарын авлага байдлаар алба хаагчид хэрэглэх боломж нөхцлийг хангах ажлыг зохион байгуулна.

118.9.21.Алба хаагчдын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг хүний нөөц, сургалт хариуцсан нэгж нэгтгэн авч, сургалтын нэгдсэн графикт тусган Цагдаагийн төв байгууллагын даргын тушаал, шийдвэрээр зохион байгуулна.

118.9.22.Гадаадад их, дээд сургууль, коллежид диплом, бакалавр, магистр, докторын зэрэглэлээр суралцагсдыг сонгон шалгаруулах, элсүүлэх, гадаадад курс семинарт суралцуулах асуудлыг Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс хариуцаж зохион байгуулна.

## **118.10.БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

118.10.1.Цагдаагийн алба хаагчдын давтан, мэргэшүүлэх, ур чадварын болон ажлын байрны үргэлжилсэн сургалтад Сургалтын төв, бүсийн сургалтын төвийн ахлах сургагч нар болон цагдаагийн мэргэжлийн албанд ажиллаж байгаа, сургагч-багш бэлтгэх сургалтад хамрагдсан, сургагч багшаар томилогдсон болон тухайн ажил, мэргэжлээр мэргэшсэн цагдаагийн алба хаагч хичээл заана.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.10.2.Сургагч-багшийг бэлтгэх, чадавхижуулах, сургалтын ажлыг нь дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 950-д зааснаар зохицуулна.

118.10.3.Их, дээд сургууль, академи болон бусад сургууль, байгууллагаас эрдэмтэн, судлаач, мэргэжлийн ажилтан, багш /сургагч/ урьж хичээл заалгах тохиолдолд зохих журмын дагуу цагийн хөлсийг олгоно.

118.10.4.Сургагч багш нарыг чадваржуулах чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

## **118.11.АЛБА ХААГЧ**

118.11.1.Цагдаагийн алба хаагч нь мэргэжил, мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, өөрөө сурч, хөгжих талаар санаачлагатай байна.

118.11.2.Цагдаагийн алба хаагч нь мэдлэг, ур чадвараа бие даан суралцах болон үргэлжилсэн сургалтад хамрагдан сургалтын багц цагийг зохих журмын дагуу хангана.

118.11.3.Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагын захиалгаар мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол эзэмших урт хугацааны сургалтад хамрагдах бол цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэстэй сургалтын гэрээ байгуулж, дүгнүүлнэ.

## **118.12.СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ**

118.12.1.Цагдаагийн байгууллагын захиалгаар сургалтын гэрээ байгуулан суралцаж байгаа алба хаагчийн гэрээний үүргийн биелэлтийг талууд жил бүр үнэлж, дүгнэнэ. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг тухайн гэрээнд тодорхой тусгаж зохицуулна.

118.12.2.Сургалтын төв болон бүсийн сургалтын төвд зохион байгуулагдсан сургалтын үр дүнг Сургалтын төв нь өөрөө үнэлж, дүгнэхээс гадна сургалтын үйл ажиллагааны болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн үнэлгээ шинжилгээг боловсролын шинжилгээ үнэлгээний байгууллагаар хийлгэж болно.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.12.3.Сургалтын төв болон бүсийн сургалтын төв нь улирал, жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг бичиж цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст ирүүлнэ.

Тайланд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ /хичээл сургалтыг үр дүнтэй явуулах боломж, нөхцөл, байр, танхим, техник хэрэгсэл, үзүүлэн, ном, гарын авлага, тэдгээрийн хангамж, хүртээмж, ашиглалт, тухайн жил, улиралд шинээр хийгдсэн, нэмэгдсэн зүйлийн нэр, тоо, хэмжээ, хичээлүүдийн лекц, хийсэн ашигласан сургалтын аудио, видео бичлэг, кино, CD, бодлого, аргачлал, зөвлөмж болон бусад баримт материалуудын эмхэтгэл, цуглуулгын нэр, төрөл, тоо хэмжээ гэх зэрэг/ албадын хамтын ажиллагаа, алба хаагчдын хичээлийн оролцоо, идэвх, /хичээлийг олон цагаар тасалсан, идэвхи, санаачлагагүй оролцсон алба хаагчийн нэр, албан тушаал/ мэдлэг, чадварын түвшинд нь гарсан өөрчлөлт, багшлах бүрэлдэхүүний сургалтын ачаалал, багшийг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, сургалтын ажлыг өмнөх жилийн мөн үетэй харьцуулж гарсан ахиц, дэвшил, цаашид анхаарах асуудлыг дэлгэрэнгүй тусгаж, холбогдох судалгааны материалыг хавсаргана.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.12.4.Цагдаагийн байгууллага бүр ажлын байранд зохион байгуулсан сургалтын явц, үр дүнг үйл ажиллагааны тайланд тодорхой тусгаж зохих журмын дагуу цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэст ирүүлнэ.

Тайланд байгууллагын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, өмнөх жилийн төлөвлөгөө, хөтөлбөрийг өөрчилж шинэчилсэн байдал, түүний шалтгаан, алба хаагчдын сургалтын оролцоо, идэвх, мэдлэг, ур чадварын түвшингийн ахиц, сургалтыг шинэлэг арга хэлбэр, сургагч-багш нарын сургалтын ажлын ачаалал, үнэлгээ, нийтийн хүртээл болгохуйц шинэ, оновчтой арга, туршлага, заагдсан хичээлүүдээр авсан шалгалт, шүүлгийн нэгдсэн дүн, үнэлгээ тэдгээрт хийсэн шинжилгээ, өнгөрсөн оны мөн үетэй нь харьцуулж өсөлт, бууралтыг гаргах, бие бүрэлдэхүүнийхээ мэдлэг, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, шинээр томилогдсон алба хаагчдыг ажилд нь сурган дадлагажуулах талаар хийсэн ажил, ажлын байран дахь сургалтын зохион байгуулалт, түүний явц, үр дүнд хийсэн хяналт шалгалт, мөрөөр нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

118.12.5.Цагдаагийн төв байгууллагын харьяа нэгж болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас ажлын байранд зохион байгуулсан сургалтын явц, үр дүнг Монгол Улсын Засгийн газраас тогтоосон ажлын үр дүнд үнэлгээ хийх журмын дагуу цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс дээрх үзүүлэлтийн агуулга нэг бүрээр улирал бүр шинжилгээ хийж, байгууллага бүрд оноо өгч байр эзлүүлэх бөгөөд тухайн жилд алба хаагчаас нь мэргэжлийн ба сахилга, ёс зүйн ноцтой алдаа гаргаж арга хэмжээ авагдсан болон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн тохиолдлыг алба хаагчдын сургалт, хөгжлийн ажлыг дүгнэхдээ харгалзах үзүүлэлт болгон авч үзнэ.



Хүний нөөц, сургалтын хэлтэс шаардлагатай гэж үзвэл зөвлөмж, аргачлалыг боловсруулан байгууллагуудад хүргүүлнэ.

118.12.6.Сургалтын төв, бүсийн сургалтын төвүүд болон цагдаагийн бусад байгууллагын сургалтын үйл ажиллагаанд үнэлгээ, шинжилгээ хийхдээ тухайн байгууллагын сургалтын ажлын тайланг үндэслэх бөгөөд шаардлагатай тохиолдолд сургалтын үйл ажиллагаатай биечлэн танилцаж үнэлэх ажлыг зохион байгуулж болно.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

### **118.13.СУРГАЛТЫН ТӨСӨВ, ЗАРДАЛ**

118.13.1.Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс хүний нөөцийн төлөвлөлтийг үндэслэн дараагийн хичээлийн жилд гадаад, дотоодын их, дээд сургуулийн дээд боловсролын зэрэг /бакалавр, магистр, доктор/-ийн сургалтад суралцуулах иргэн, алба хаагчийн хяналтын тоог тогтоох саналыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох сургалтын байгууллагад, тухайн сургалттай холбогдох төсөв, зардлын саналыг Санхүү, хангамжийн газарт жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

118.13.2.Гадаад, дотоодод зохион байгуулагдах богино хугацааны давтан, мэргэшүүлэх болон бусад сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явагдах сургалттай холбогдох зардлын төсвийг Сургалтын төв боловсруулж, цагдаагийн байгууллагын дараагийн жилийн төсөвт тусгуулах саналыг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Санхүү, хангамжийн газарт хүргүүлнэ.

*/Энэ заалтад ЦЕГ-ын даргын 2015 оны А/39 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон./*

118.13.3.Дараагийн жилд цагдаагийн байгууллагын хэмжээнд цагдаагийн мэргэжил, боловсролын зэрэг, шатлалаар суралцуулах алба хаагчийн хяналтын тоог боловсрол, хууль зүй, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай зөвшилцөн байгууллагын төсөв болон цагдаагийн төв байгууллагын хөгжлийн сангийн төсөв, төлөвлөгөөнд тусгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх үүргийг Санхүү, хангамжийн газар хүлээнэ.

118.13.4.Гадаад, дотоодын их, дээд сургуулийн магистр, докторын болон удирдах албан тушаалтан бэлтгэх сургалтад төрийн сангийн тэтгэлэг, зээлээр суралцаж байгаагаас бусад алба хаагч мөн албаны ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа гаргаж албадан сургалтад хамрагдсан алба хаагч сургалтын төлбөрөө өөрөө хариуцна.

118.13.5.Сургалтаас чөлөөлөгдсөн алба хаагчийн сургалтад хамрагдсан хугацааны цалин хөлсийг олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.